



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/62 АУА-2018/56/СТА-ТЦУЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2,090,511.00 төгрөгийг шилжүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүдэхийг Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга Э.Саруулжаргал, нягтлан бодогч Б.Өрнөхбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АХЛАХ АУДИТОР Т.БАТСАЙХАН

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА Э.САРУУЛЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ Б.ӨРНӨХБАЯР

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/62 АУА-2018/СБКА-ТЦЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2,090,511.00 төгрөгийг шилжүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга Э.Саруулжаргал, нягтлан бодогч Б.Өрнөхбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН!:

АХЛАХ АУДИТОР Т.БАТСАЙХАН

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА Э.САРУУЛЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ Б.ӨРНӨХБАЯР

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт-хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/